



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,  
<http://www.mmhi.gov.mn>

2018.01.10 № 01/83


таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай 67 дугаар тогтоолын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2017 онд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайлан, танилцуулгыг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 7 хуудастай.



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД ИРГЭД, БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖЭЭС ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН  
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН, МЭДЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар нь байгууллага, иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх ажиллагааг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол Улсын хууль, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол бусад хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байна.

Хүлээн авсан өргөдөл, гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал, зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж, яамны Удирдлагын зөвлөлийн хуралдаанд танилцуулан дүгнэлт, шийдвэр гаргуулан, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэн ажиллаж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 850 өргөдөл, гомдол ирсэн ба үүнээс иргэд, байгууллагаас 752, дээд газар, УИХ-ын гишүүдээс шилжүүлэн ирүүлсэн 20, Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн 51, утсаар хандсан 8, биечлэн уулзсан 17, бусад 2 өргөдөл, гомдол байна. Эдгээрээс шийдвэрлэж хариу өгсөн 803, хугацаа хэтэрсэн 28, хугацаа болоогүй 19 өргөдөл, гомдол байна.

Иргэдээс төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 95.0 хувьтай байна.

Агуулгаар нь ангилж үзэхэд, 700 өргөдөл /хүсэлт/, 145 гомдол, 5 санал байгаагаас хүний нөөцийн асуудлаар 214, тусгай зөвшөөрөлтэй холбоотой 61, геологийн салбартай холбоотой 19, хүнд үйлдвэрийн салбартай холбоотой 6, уул уурхайн салбартай холбоотой 48, шүүхийн нэхэмжлэлтэй холбоотой 355, бусад 147 байна. Хүний нөөцийн асуудалд ажилд орох, томилуулах, ажлаас чөлөөлүүлэх, чөлөө хүсэх, мөнгөн тусламж, дэмжлэг хүсэх зэрэг асуудлууд

хамрагдаж байна. Яам, агентлагийн асуудал хариуцсан нэгж, албан тушаалтнууд нь өргөдөл, гомдолд тавьсан хүсэлт, асуудлуудыг судлан үзэж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих шийдвэр гарган, хариу өгч ажилласан.

Хугацаа хэтэрсэн 28 өргөдөл, гомдлоос хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалттай холбоотой 8 гомдлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/221 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд судлан үзэж, дүгнэлт гаргасан. Ажлын хэсгийн тайлантай Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд танилцаж, албажуулсны дараа дээрх гомдол гаргагч аж ахуйн нэгжүүдэд хариуг хүргүүлэхээр ажиллаж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хандаж ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд, шаардлагын түвшинд явагдсан гэж дүгнэж байна.

Иргэдээс төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг хүснэгт 1, хэлбэрийг хүснэгт 2, агуулгыг хүснэгт 3-аар тус тус гарган танилцуулганд хавсаргасан.

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

Хавсралт /...

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
/Байгууллагын нэр/

Хүснэгт №1

**2017 онд иргэдээс төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн  
өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал**

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт %
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Хугацаа боловгуй	
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	850	803	0	28	19	95.0 %

**2017 онд дээд газар, УИХ-ын гишүүдээс шилжүүлэн ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал**

№	Үүнээс						Шийдвэрлэсэн		Хугацаа боловгуй /шийдвэрлэх шатанд/
	Ерөнхийлөгчийн тамгын газраас	УИХ-ын Өргөдлийн Б.Хороо	УИХ-ын гишүүнээс	ЗГХЭГ-аас	ХЗЯ-аас	Төрийн албаны зөвлөлөөс	Хугацаанд нь	Хугацаа хэтэрч	
1		3	9	7	0	1	11	9	

Хүснэгт №2

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
/Байгууллагын нэр/

2017 оны байдлаар иргэдээс төрийн захиргааны төв байгууллагад  
хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт /хэлбэрээр/

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:					
			Бичгээр	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	850	772	51	-	8	17	2

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
/Байгууллагын нэр/

**Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга**

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Нийт 850 өргөдлөөс <ul style="list-style-type: none"> <li>• Өргөдөл /хүсэлт/ 700; 82.3 %</li> <li>• Гомдол 145; 17.0%</li> <li>• Санал 5; 0.7 %</li> </ul> 1. Шүүхийн нэхэмжлэлтэй холбоотой 355; 41.8% 2. Хүний нөөцийн асуудлаар 214; 25.2% 3. Бусад 147 17.0% 4. Тусгай зөвшөөралтэй холбоотой 61; 7.2% 5. Уул уурхайн салбартай холбоотой 48; 5.6% 6. Геологийн салбартай холбоотой 19; 2.2% 7. Хүнд үйлдвэрийн салбартай холбоотой 6; 1.0%

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

УУХҮЯ-нд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс гаргасан өргөдөл, гомдлын  
шийдвэрлэлтийн зарим үзүүлэлтийн нэгтгэл

2018.01.10

/2017 оны жилийн эцсийн байдлаар/

д д	Тайлаг насан хугацаа	Өргөдөл, гомдлын тоо			Шийдвэрлэлтийн хувь			Хугацаа хэтэрсэн		
		УУХҮЯ	АМГТГ	Нийт	УУХҮЯ	АМГТГ	Нийт	УУХҮЯ	АМГТГ	Нийт
1	I улирал	19	174	193	78.9	86.8	86.0	3	5	8
2	II улирал	46	250	296	82.6	93.8	91.9	4	3	7
3	III улирал	83	522	605	97.6	92.1	92.9	0	0	0
4	IV улирал	179	671	850	92.7	97.4	95.0	11	17	28

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

*Хөвсргэлт 3*



**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯМНЫ  
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭС**

**2018** оны **01** сарын **10** өдөр

Дугаар **01**

Төслийн нийтийн талаар

Уул уурхай, хүнд үйлдвэрийн ямны Удирдлагын зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

1. Яамны эрхлэх асуудлаар гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2017 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээ хийсэн тухай Хяналт-шинжилгээ, үналгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Б.Баяржаргал танилцуулав.

2. Яаманд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар гаргасан 2017 оны жилийн эцсийн тайлан, мэдээний тухай Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Н.Баатар танилцуулав.

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2017 оны жилийн эцсийн байдлаар хийсэн үнэлгээ болон өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2017 оны жилийн эцсийн тайлан, мэдээний тухай танилцууллыг холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд нь Засгийн газрын хэрэг зэрхэг эрхлэх газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТӨРИЙН  
ДАРГА



Г.НАНДИНЖАРГАЛ